



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗРЫН 2021 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/162/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Сэржмядаг
Утас: 261885 Цахим хаяг: serjmyadagb@audit.gov.mn
Ахлах аудитор: Ц.Энхжаргал
Утас: 261628 Цахим хаяг: enkhjargalts@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК
Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг
Утас: 70003775 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн төсвийн нэмэлт санхүүжилтийн тайлан	11
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт	17
4.1 Залруулсан алдаа	17
4.2 Төлбөрийн акт	17
4.3 Албан шаардлага	17
4.4 Зөвлөмж.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
МУИХ	Монгол Улсын Их Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгал
ХЧТАТ	Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

1. Аудитын санал дүгнэлт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага гойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.02.25 № 04/393
танай _____ -ны № _____ -т

ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН
ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗРЫН
ДАРГА Г.ГАНТУЛГА ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 448,275.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч тогтоосон материаллаг байдлын түвшингээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн "Тохиолдсон байх", "Үнэн зөв байдал", "Толилуулга ба тодруулга", "Эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2022\0225 Auditin 2 Gazar -8.Docx

001050317

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	55,024,944.00	39,651,647.90
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,422.00	-
312	Кассад байгаа бэлэн мөнгө	1,422.00	-
3121	Төгрөг	1,422.00	-
31210	Төрийн сангийн харилцах	-	-
33	АВЛАГА	700,000.00	2,819,424.90
33100	Ажиллагсадтай холбогдсон авлага	-	2,819,424.90
33300	Татаас санхүүжилтийн авлага	700,000.00	
34	УРЬДЧИЛГАА	-	-
34600	Урьдчилж гарсан зардал	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	54,323,522.00	36,832,223.00
35420	Хангамжийн материал	54,323,522.00	36,832,223.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	50,596,904.06	130,005,046.96
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	50,596,904.06	130,005,046.96
392	Биет хөрөнгө	50,596,904.06	128,942,546.96
39203	Авто-тээврийн хэрэгсэл	57,257,530.00	57,257,530.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(35,521,042.50)	(42,973,552.50)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	66,245,900.00	124,820,354.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(50,230,037.15)	(64,095,469.41)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	47,811,306.21	58,504,709.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(34,966,752.50)	(4,571,024.13)
393	Биет бус хөрөнгө	-	1,062,500.00
39301	Программ хангамж	65,188,490.00	66,688,490.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(65,188,490.00)	(65,625,990.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	16,092,500.00	16,092,500.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(16,092,500.00)	(16,092,500.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ҮР ДҮН	105,621,848.06	169,656,694.86
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	30,488,071.29	-
413	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	30,488,071.29	-
41310	Ажилчидтай холбогдох өглөг	29,788,071.29	
41360	Бусад өглөг	700,000.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	75,133,776.77	169,656,694.86
51	Засгийн газрын хувь оролцоо	75,133,776.77	169,65,694.86
51101	Өмч-Төрийн өмч	186,808,521.00	186,808,521.00
512	Хуримтлагдсан үр дүн	(111,674,744.23)	(17,151,826.14)
51210	Өмнөх үеийн үр дүн	(99,434,400.16)	(111,674,744.23)
51220	Тайлант үеийн үр дүн	(12,240,344.07)	94,522,918.09
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	105,621,848.06	169,656,694.86

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,053,416,300.00	1,200,742,109.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,681,800.00	280,000.00
122	Нийтлэг татварын бус орлого	3,681,800.00	280,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	3,681,800.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	280,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	280,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,049,734,500.00	1,200,462,109.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,009,734,500.00	1,110,837,139.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,009,734,500.00	1,014,861,300.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	-	95,975,839.00
131101	Нэмэлт санхүүжилтийн орлого	40,000,000.00	89,624,970.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	40,000,000.00	43,624,970.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	-	46,000,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,073,862,794.14	1,103,375,172.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,073,862,794.14	1,103,375,172.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,052,605,326.04	1,057,785,389.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	607,458,781.34	572,944,080.09
210101	Үндсэн цалин	528,054,694.34	497,524,059.00
210102	Нэмэгдэл	52,944,087.00	48,222,204.09
210103	Унаа хоолны хөнгөлөлт	26,460,000.00	27,197,817.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,877,595.29	77,980,797.82
210201	Тэтгэврийн даатгал	57,923,535.28	52,228,117.20
210202	Тэтгэмжийн даатгал	5,820,733.97	5,919,227.62
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,681,400.00	5,095,587.50
210204	Ажилгүйдлийн даатгал	1,707,138.00	1,248,896.80
210205	Эрүүл мэндийн даатгал	11,744,788.04	13,488,968.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,143,080.00	16,706,655.92
210301	Гэрэл, цахилгаан	-	82,922.92
210304	Байрны түрээс	10,143,080.00	16,623,733.00
2104	Хангамж, бараа материалын зардал	173,936,540.50	193,629,341.64
210401	Бичиг хэрэг	65,348,808.00	58,452,457.00
210402	Тээвэр, шатахуун	14,375,941.64	16,156,274.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	19,228,670.86	20,045,079.64
210408	Бараа материал акалсны зардал	74,983,120.00	98,975,531.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	716,000.00	453,500.00
210601	Багаж техник хэрэгсэл	716,000.00	-
210604	Урсгал засвар	-	453,500.00
2107	Томиллолт, зочны зардал	624,340.00	200,000.00
210702	Дотоод албан томиллолт	-	200,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	624,340.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	148,426,895.00	159,386,432.11
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	127,820,185.00	130,253,804.11
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	2,02,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	17,031,600.00	16,501,270.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	209,400.00	160,734.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,070,756.00	9,941,500.00
210807	Газрын төлбөр	294,954.00	465,124.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,422,093.91	36,484,581.59
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,002,950.07	9,500,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	15,419,143.84	26,984,581.59
27	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,257,468.10	45,309,783.23
	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	1,422,687.29
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	-	1,422,687.29
	Бусад урсгал шилжүүлэг	19,668,516.00	27,723,737.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	19,668,516.00	23,523,251.40
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	4,200,485.60
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,588,952.1	16,443,358.94
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,588,952.10	16,443,358.94
	Хөрөнгийн зардал	-	2,844,018.51
	Дотоод эх үүсвэрээр	-	2,844,018.51
223001	Бусад хөрөнгө	-	2,844,018.51
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(20,446,494.14)	94,522,918.09
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (4)	8,206,150.07	-
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	8,206,150.07	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(12,240,344.07)	94,522,918.09

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	164,450,991.00	3,340,874.47	(102,775,274.63)	65,016,590.84
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, залруулга	-	-	3,340,874.47	3,340,874.47
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	164,450,991.00	3,340,874.47	(99,434,400.16)	68,357,465.31
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	22,357,530.00	-	-	22,357,530.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	(3,340,874.47)	-	(3,340,874.47)
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(12,240,344.07)	(12,240,344.07)
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	186,808,521.00	0.00	(111,674,744.23)	75,133,776.77
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, залруулга	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	186,808,521.00	0.00	(111,674,744.23)	75,133,776.77
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	94,522,918.09	94,522,918.09
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	186,808,521.00	0.00	(17,151,826.14)	169,656,694.86

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,050,434,500.00</u>	<u>1,200,742,109.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,050,434,500.00	1,200,742,109.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,009,734,500.00	1,070,861,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,009,734,500.00	1,014,861,300.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт		56,000,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	40,000,000.00	33,624,970.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	40,000,000.00	33,624,970.00
	Төсвийн захирагчдаас		95,975,839.00
133003	Хөрөнгийн		95,975,839.00
	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	700,000.00	280,000.00
140020	Бусад орлого	700,000.00	280,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,050,434,500.00</u>	<u>1,091,506,788.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,050,434,500.00	1,091,506,788.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,022,445,347.90	1,047,665,335.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	585,173,500.00	574,448,437.73
210101	Үндсэн цалин	402,872,675.95	408,395,260.73
210102	Нэмэгдэл	129,380,824.05	113,133,177.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	52,920,000.00	52,920,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,998,500.00	76,133,308.13
210201	Тэтгэврийн даатгал	55,591,500.00	54,677,808.13
210202	Тэтгэмжийн даатгал	5,851,700.00	5,363,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,681,400.00	4,291,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,170,400.00	1,072,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,703,500.00	10,728,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,784,000.00	16,706,655.92
210301	Гэрэл, цахилгаан	-	82,922.92
210304	Байрны түрээс	12,784,000.00	16,623,733.00
2104	Хангамж, бараа материалын зардал	51,082,526.90	65,150,524.75
210401	Бичиг хэрэг	15,706,626.90	12,539,059.00
210402	Тээвэр, шатахуун	11,078,500.00	20,218,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	17,614,800.00	16,696,865.75
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,682,600.00	15,696,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,918,500.00	4,676,350.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,167,000.00	3,274,850.00
210604	Урсгал засвар	751,500.00	1,401,500.00
2107	Томилолт, зочны зардал	2,044,300.00	761,000.00
210702	Дотоод албан томилолт	-	761,000.00

210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,044,300.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	274,194,821.00	263,789,059.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	243,898,700.00	229,842,711.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	17,031,600.00	16,501,270.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	209,400.00	228,134.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	97,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	12,663,167.00	14,707,820.00
210807	Газрын төлбөр	294,954.00	465,124.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,249,200.00	46,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,049,200.00	46,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,200,000.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,989,152.10	43,841,452.47
	Засгийн газрын урсгал шилжүүлэг		1,422,687.29
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг		1,422,687.29
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,700,200.00	25,975,406.24
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	23,481,254.00	24,883,406.24
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,218,946.00	1,092,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,288,952.10	16,443,358.94
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,288,952.10	16,443,358.94
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	=	<u>109,235,321.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (4)	-	109,236,743.00
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	109,236,743.00
	Дотоод эх үүсвэрээр	-	109,236,743.00
	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	109,236,743.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (5)=(3)-(4)	-	(109,236,743.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	(1,422.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,422.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,012,677,600.00	998,699,363.06	16,161,936.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,012,677,600.00	998,699,363.06	16,161,936.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	986,698,100.00	971,301,269.53	16,157,830.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	585,173,500.00	574,448,437.73	10,725,062.27
210101	Үндсэн цалин	422,770,000.00	408,395,260.73	14,374,739.27
210102	Нэмэгдэл	109,483,500.00	113,133,177.00	(3,649,677.00)
210103	Унаа хоолны хөнгөлөлт	52,920,000.00	52,920,000.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,998,400.00	76,133,308.13	2,865,091.87
210201	Тэтгэврийн даатгал	55,591,500.00	54,677,808.13	913,691.87
210202	Тэтгэмжийн даатгал	5,851,700.00	5,363,600.00	488,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,681,400.00	4,291,100.00	390,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,170,300.00	1,072,500.00	97,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,703,500.00	10,728,300.00	975,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,855,400.00	16,706,655.92	148,744.08
210301	Гэрэл, цахилгаан	221,400.00	82,922.92	138,477.08
210304	Байрны түрээс	16,634,000.00	16,623,733.00	10,267.00
2104	Хангамж, бараа материалын зардал	67,561,300.00	65,150,524.75	2,410,775.25
210401	Бичиг хэрэг	12,540,000.00	12,539,059.00	941.00
210402	Тээвэр, шатахуун	20,218,000.00	20,218,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	19,103,000.00	16,696,865.75	2,406,134.25
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	15,700,300.00	15,696,600.00	3,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,363,400.00	9,363,330.00	70.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,961,900.00	7,961,830.00	70.00
210604	Урсгал засвар	1,401,500.00	1,401,500.00	-
	Томилолт, зочны зардал	761,000.00	761,000.00	
210702	Дотоод албан томилолт	761,000.00	761,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	228,746,100.00	228,738,013.00	8,087.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	194,798,700.00	194,791,665.00	7,035.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	16,501,300.00	16,501,270.00	30.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	228,200.00	228,134.00	66.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	44,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	14,708,700.00	14,707,820.00	880.00
210807	Газрын төлбөр	465,200.00	465,124.00	76.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,979,500.00	27,398,093.53	4,106.47
	Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,422,700.00	1,422,687.29	12.71
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	1,422,700.00	1,422,687.29	12.71
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,979,500.00	25,975,406.24	4,093.76
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	24,887,500.00	24,883,406.24	4,093.76
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,092,000.00	1,092,000.00	-
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		95,975,839.00	(95,975,839.00)
	Дотоод эх үүсвэрээр		95,975,839.00	(95,975,839.00)
223001	Тоног төхөөрөмж		95,975,839.00	(95,975,839.00)
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,014,861,300.00	998,699,363.06	16,161,936.94
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,014,861,300.00	998,699,363.06	16,161,936.94
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,014,861,300.00	998,699,363.06	16,161,936.94
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,422.00	(1,422.00)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-	-
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	36	36	-
	Удирдах ажилтан	1	1	-
	Гүйцэтгэх ажилтан	32	32	-
	Үйлчлэх ажилтан	3	3	-

2.6 Аудит хийсэн төсвийн нэмэлт санхүүжилтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	89,624,970.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	89,624,970.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	89,624,970.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	43,624,970.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		46,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		46,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	89,624,970.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт		56,000,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	33,624,970.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	33,624,970.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад үндсэн хөрөнгө, цалингийн тооцоолол тайлагнахыг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 26-наас 2022 оны 2 дугаар сарын 18-ны хооронд Хаан консалтинг аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал Э.Нандинчимэг, аудитор Ш.Мөнхцэцэг, аудиторын туслах Д.Дарь нар гүйцэтгэж, хяналтыг чанарын хяналтын менежер Г.Ганцэцэг хэрэгжүүлсэн.

Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 01/172 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Засгийн газрын 2004 оны 222 дугаар тогтоолын дагуу Засгийн газрын тохируулагч агентлаг “Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах газар” нэртэйгээр байгуулагдсан.

Монгол улсад аж ахуй эрхлэгчдийн зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, зах зээлд ноёлох болон өрсөлдөөнд харш аливаа үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, хориглон хязгаарлах, өрсөлдөөнийг зохицуулах замаар хэрэглэгчийг чанартай бараа, ажил үйлчилгээгээр хангаж, тэдний эрхийг хамгаалахад оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллага нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлагналдаа мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт шинэчлэл хийгдээгүй боловч Төсвийн тухай хууль болон УСНББОУС-д нийцүүлэн Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”, “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар”-ыг мөрдсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн 1,014,861.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 10,148.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 64,034.8 мянган төгрөгөөр буюу 37.7 хувиар өсөж, материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1.42	-	(1.42)
Авлага	700.00	2,819.42	2,119.42
Бараа материал	54,323.52	36,832.22	(17,491.30)
Үндсэн хөрөнгө	50,596.90	130,005.05	79,408.14
Нийт хөрөнгө	105,621.85	169,656.69	64,034.85
Өр төлбөр	30,488.07	-	(30,488.07)
Хуримтлагдсан үр дүн	75,133.78	169,656.69	94,522.92
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	105,621.85	169,656.69	64,034.85

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Бараа материалын дансны эхний үлдэгдэл бичиг хэргийн материал, аж ахуйн материалаас 4,065.8 мянган төгрөгийг зарцуулж, 13,425.5 мянган төгрөгийн бусад хангамжийн материалыг данснаас хассан;
- Үндсэн хөрөнгө данс нь 109,236.7 мянган төгрөгийн компьютер, тавилга эд хогшил, программ худалдан авсан ба ТӨБЗГ-ын 2018 оны А-3/4794 дугаар тогтоолоор 38,468.8 мянган төгрөгийн хөрөнгийг данснаас хассан болон элэгдлийн зардлаас голлон шалтгаалж 79,408.1 мянган төгрөгөөр өссөн;

- Өр төлбөр данс өмнөх оны цалингийн өглөг 29,788.0 мянган төгрөг, байгууллагад өгөх өглөг 700.0 мянган төгрөгийн өглөгөөр буурсан.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны санхүүжилтийн эх үүсвэрийг 1,114,861.3 мянган төгрөг, үүнээс урсгал зардалд 1,014,861.3 мянган төгрөг, хөрөнгө оруулалтын зардалд 100,000.0 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн захирагчаас санхүүжилтийн эх үүсвэрийг урсгал зардалд 1,014,861.3 мянган төгрөг, хөрөнгө оруулалтын зардалд 100,000.0 мянган төгрөгийн зарцуулалтыг баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,114,861.3 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр урсгал үйл ажиллагаанд 1,014,861.3 мянган төгрөг, хөрөнгө оруулалтын зардалд 95,975.8 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч, 99.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 998,699.3 мянган төгрөг буюу 98.6 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 13,590.2 мянган төгрөг, хангамж бараа материалын зардлыг 2,410.7 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой зардлыг 148.7 мянган төгрөг, бусдаар гүйцэтгэсэн ажил үйлчилгээний төлбөр болон урсгал шилжүүлгийн зардлыг 12.4 мянган төгрөгөөр дутуу зарцуулснаас шалтгаалсан байна.

Хүснэгт-3 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	70410	Улсын төсвөөс санхүүжих	1,014,861.3	998,699.3	16,162.0	98.6
1.1	80101	Үйл ажиллагааны урсгал зардал	1,014,861.3	998,699.3	16,162.0	98.6
1.2	80918	Хөрөнгийн зардал	-	95,975.8	-	-

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд НҮБ-ийн Хүүхдийн сангаас 33,624.9 мянган төгрөг, ЗГ-ын 2020 оны “Хөрөнгө гаргах тухай” 240 дугаар тогтоолоор 46,000.0 мянган төгрөг, МУИХ-ын

нөхөн сонгуулийг мониторинг хийхэд зориулан Сонгуулийн ерөнхий хорооноос 10,000.0 мянган төгрөгийн нийт 89,624.9 мянган төгрөгийн нэмэлт орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 46,000.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 43,624.9 мянган төгрөг зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтээр орсон орлого, зардлын зарцуулалтыг зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд төслийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 1 хөтөлбөр, 5 арга хэмжээний хэрэгжилт 99.5 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 98.4 хувийн биелэлттэй, 1.6 хувь буюу 16,162.0 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас авсан судалгааг нэгтгэн дүгнэхэд худалдан авсан бараа ажил үйлчилгээний төлбөрт 28,624.9 мянган төгрөгийг зар сурталчилгааны тухай хуулийн төслийг боловсруулахаар 2 төрийн бус байгууллагад шилжүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Аудитын явцад шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд тайлант хугацаанд оруулбал зохих 150 мэдээллээс хугацаандаа оруулсан 141 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, худалдан авах ажиллагаа, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө байршуулаагүй хугацаа хоцроосон 7 мэдээлэл байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “Тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх” гэсэн заалттай нийцээгүй эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан холбогдох ажилтанд хариуцлага тооцох шаардлага өгөх.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант оны төсвийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож байгууллагын тушаал шийдвэр гаргаагүй, хэмнэлт гаргаагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1 дүгээр зүйлд “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээд шатны байгууллагаас гаргасан шийдвэрийг үйл ажиллагаандаа мөрдөх, зөрчлийг давтан гаргахгүй байх, албан шаардлага өгөх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай тогтоолын заалттай тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 2,172.5 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгч, жилийн эцсийн аудитаар дахин хянахад хэрэгжүүлээгүй байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн шилэн дансны цахим хуудсанд 17 мэдээг байршуулаагүй, цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, шатахуун зарцуулалтад жишиг нормыг мөрдөөгүй зөрчилд 3 албан шаардлагын биелэлт 57.1 хувь, 11,306.3 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилт 93.0 хувьтай байна.

Хүснэгт-4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	3	-	1	-	2	-	57.1
Зөвлөмж	2	11,306.3	1	10,520.1	1	786.2	93.0
Нийт дүн	5	11,306.3	2	10,520.1	1	786.2	75.0

Жижиг мөнгөн санд зөвшөөрөгдсөн хэмжээнээс их орлого, зарлагын гүйлгээ хийсэн зөвлөмжийг хэрэгжүүлж, НДШ, ХХОАТ-ын хөнгөлөлтийг илүү тооцоолсон талаар өгсөн зөвлөмжийн зөрчлийг 786.2 мянган төгрөгөөр давтан гаргасан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх асуудал байхгүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 449,013.9 мянган төгрөгийн 7 алдаа зөрчил илэрснээс, 738.3 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 761.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 444,204.9 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, 3,309.2 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй 6 алдаа, зөрчлийн дүн 448,275.1 мянган төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 10,148.6 мянган төгрөгөөс хэтэрсэн тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай шатахууны зарцуулаагүй үлдэгдэл 738.3 мянган төгрөгийг зардлаар тайлагнасныг залруулан санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав

4.2 Төлбөрийн акт

1. Эрх бүхий албан тушаалтны шийдвэр, удирдамж, хөтөлбөр, илтгэх хуудас зэрэг анхан шатны дэмжих баримтгүй 761.0 мянган төгрөгийн томилолтын зардал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, иж бүрэн ба үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтын иж бүрэн байдлыг хангасан гүйлгээг бүртгэлд тусган ажиллах, Төлбөрийн акт өгөх.

4.3 Албан шаардлага

1. Анхан шатны иж бүрэн баримтын бүрдэлгүй 16,156.3 мянган төгрөгийн шатахууны зардал, 10,945.0 мянган төгрөгийн халдвар хамгаалалтын эд зүйлс нийт 27,101.3 мянган төгрөгийн зарцуулалт байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, иж бүрэн ба үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтыг иж бүрэн хөтлөх, хяналт тавьж ажиллах, Албан шаардлага өгөх.

2. Жилийн эцсээрх 240,582.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 36,832.2 мянган төгрөгийн бараа материал нийт 277,414.7 мянган төгрөгийн тооллогын баримтыг ирүүлээгүй, байгууллагын даргын тушаал шийдвэргүй 13,425.5 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгийг данснаас хассан, 8,876.5 мянган төгрөгийн эргэлтийн бус хөрөнгийн шинжтэй хөрөнгө нийт 299,716.7 мянган төгрөгийн буруу тайлагнал байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах,

удирдах, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.1-д Худалдах, шилжүүлэх, устгах эд хөрөнгийн талаар өмч хамгаалах Байнгын зөвлөл дүгнэлт гаргасан байх гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, тодруулга ба толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийг удирдлагын шийдвэрийн дагуу данснаас хасах, тооллогыг тогтоосон хугацаанд чанартай хийх, хөрөнгийг стандартын дагуу ангилан санхүүгийн тайланд тусгах, Албан шаардлага өгөх.

3. ХХОАТ-ын тайланд сонгуулийн гэрээт ажилтнуудын 12,429.8 мянган төгрөгийн цалинг тайлагнаагүйгээс 2,819.4 мянган төгрөгийн ХХОАТ-ын авлагыг тайлагнасан ба тооцоо нийлж баталгаажуулаагүй, хөгжлийн бэрхшээлтэй 2 ажилтнаас 566.6 мянган төгрөгийн татвар суутгасан нийт 15,815.8 мянган төгрөгийг буруу тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах, 20.2.4-д Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6-д Үндсэн ажлын газраас бусад хуулийн этгээд болон хувь хүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, иж бүрэн ба үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тайлант жилийн эцсийн үлдэгдэлд тайлагнасан авлагын үлдэгдлийг баталгаажуулж, тайланг үнэн зөв бэлтгэх, ХХОАТ-ын хуулийн дагуу татвар суутгахгүй байх, Албан шаардлага өгөх.

4. Тайлант онд 46 ААН-ээс 101,571.1 мянган төгрөгийн худалдан авалтын НӨАТ-ын төлбөрийн цахим баримт гаргуулан аваагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврын 5-д Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм гэсэн заалттай нийцээгүй тохиолдсон байх ба эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авалтын ажил гүйлгээний төлбөрийн цахим баримтыг бэлтгэн нийлүүлэгчээс бүрэн гаргуулах авах, татварын цахим системээр худалдан авалтыг тухай бүрэн хянаж ажиллах, Албан шаардлага өгөх.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн дансанд биет горимыг хэрэгжүүлэхэд дансанд бүртгэлгүй 26 ширхэг 2,172.5 мянган төгрөгийн цаашид ашиглах боломжтой хөрөнгийг дансанд тусгаагүй байна.

Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 тогтоолын 7 дугаар зүйлийн 7.1-д Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ гэснийг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Өгсөн зөвлөмж:

НББ-д бүртгэлгүй хөрөнгийг бүртгэж, эд хариуцагчтай болгох.

2. Цалингийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Нэг ажилтны хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийн 786.2 мянган төгрөгийг НДШ-ийн тайланд тайлагнасан, ээлжийн амралтын 1,386.6 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал олгохдоо 350.5 мянган төгрөгийн НДШ суутгаагүй олгосон нийт 1,136.7 мянган төгрөгийн буруу тайлагнал байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-д Энэ зүйлд зааснаас бусад тохиолдолд тэтгэвэр, тэтгэмжээс суутгал хийхийг хориглоно гэснийг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Өгсөн зөвлөмж:

Цалингийн суутгалыг хуулийн дагуу суутган тайлагнах, тэтгэмжийг суутгал хийхгүй бүрэн олгох.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс																			
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж											
					тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	тоо	дүн	Тоо	дүн										
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар																										
1	ШӨХТГ	АХГ-2022/162/НА-СТА-ТШЗ	Эрх бүхий албан тушаалтны шийдвэр, удирдамж, хөтөлбөр, илтгэх хуудас зэрэг анхан шатны дэмжих баримтгүй 761.0 мянган төгрөгийн томилолтын зардал олгосон байна.	Анхан шатны иж бүрэн баримтгүй гүйлгээг бүртгэсэн.	1	761.0					1	761.0														
2	ШӨХТГ	АХГ-2022/162/НА-СТА-ТШЗ	Жилийн эцсээрх 240,582.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 36,832.2 мянган төгрөгийн бараа материал нийт 277,414.7 мянган төгрөгийн тооллогын баримтыг ирүүлээгүй, байгууллагын даргын тушаал шийдвэргүй 13,425.5 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгийг данснаас хассан, 8,876.5 мянган төгрөгийн эргэлтийн бус хөрөнгийн шинжтэй хөрөнгө нийт 299,716.7 мянган төгрөгийн буруу тайлагнал байна.	Үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг ирүүлээгүй	1	299,716.7					1	299,716.7														
3	ШӨХТГ	АХГ-2022/162/НА-СТА-ТШЗ	ХХОАТ-ын тайланд сонгуулийн гэрээт ажилтнуудын 12,429.8 мянган төгрөгийн цалинг тайлагнаагүйгээс 2,819.4 мянган төгрөгийн ХХОАТ-ын авлагыг тайлагнасан ба тооцоо нийлж баталгаажуулаагүй, хөгжлийн бэрхшээлтэй 2 ажилтнаас 566.6 мянган төгрөгийн татвар суутгасан нийт 15,815.8 мянган төгрөгийг буруу тайлагнасан байна.	ХХОАТ холбоотой буруу тооцоолол, алдаатай тайлагнасан	1	15,815.8					1	15,815.8														
4	ШӨХТГ	АХГ-2022/162/НА-СТА-ТШЗ	Тайлант онд 46 ААН-ээс 101,571.1 мянган төгрөгийн худалдан авалтын НӨАТ-ын төлбөрийн цахим баримт гаргуулан аваагүй байна.	Цахим төлбөрийн баримтыг бэлтгэн нийлүүлэгчээс бүрэн гаргуулж аваагүй	1	101,571.1					1	101,571.1														
5	ШӨХТГ	АХГ-2022/162/НА-СТА-ТШЗ	Анхан шатны иж бүрэн баримтын бүрдэлгүй 16,156.3 мянган төгрөгийн шатахууны зардал, 10,945.0 мянган төгрөгийн халдвар хамгаалалтын эд	Анхан шатны иж бүрэн баримтгүй гүйлгээг бүртгэсэн.	1	27,101.3					1	27,101.3														

Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

			зүйлс нийт 27,101.3 мянган төгрөгийн зарцуулалт байна.													
6	ШӨХТГ	АХГ-2022/162/НА-СТА-ТШЗ	Үндсэн хөрөнгийн дансанд биет горимыг хэрэгжүүлэхэд дансанд бүртгэлгүй 26 ширхэг 2,172.5 мянган төгрөгийн цаашид ашиглах боломжтой хөрөнгийг дансанд тусгаагүй байна.	Ашиглах боломжтой хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоогоогүй байна	1	2,172.5									1	2,172.5
7	ШӨХТГ	АХГ-2022/162/НА-СТА-ТШЗ	Нэг ажилтны хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийн 786.2 мянган төгрөгийг НДШ-ийн тайланд тайлагнасан, ээлжийн амралтын 1,386.6 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал олгохдоо 350.5 мянган төгрөгийн НДШ суутгаагүй олгосон нийт 1,136.7 мянган төгрөгийн буруу тайлагнал байна.	НДШ-ийн тайланд ХЧТАТэтгэмжийг буруу тайлагнасанатай	1	1,136.7									1	1,136.7
8	ШӨХТГ	АХГ-2022/162/НА-СТА-ТШЗ	Шатахууны зарцуулаагүй үлдэгдэл 738.3 мянган төгрөгийг зардлаар тайлагнасан.	СБТайлан болон СҮДТайланд залруулгыг хийсэн.	1	738.3	1	738.3								
Дүн					8	449,013.4	1	738.3	1	761.0	4	444,204.9	0	0	2	3,309.2
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал																
1	ШӨХТГ	АХГ-2022/162/НА-СТА-ТШЗ	Шилэн дансны цахим хуудсанд нийтийн болон хувийн ашиг сонирхол зохицуулах, батлагдсан төсвийн хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэлийн 7 мэдээг хугацаа хоцроон оруулсан байна.	Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.	1					1				1		
2	ШӨХТГ	АХГ-2022/162/НА-СТА-ТШЗ	Тайлант оны төсвийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож байгууллагын тушаал шийдвэр гаргаагүй, хэмнэлт гаргаагүй байна.	Дээд шатны байгууллагаас гаргасан шийдвэрийг үйл ажиллагаандаа мөрдөх	1					1						
Дүн					1					2				1		
Нийт					10	449,013.4	1	738.3	1	761.0	6	444,204.9	1	0	2	3,309.2



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 02 дугаар сарын 25

№ 25/ А0150058

Улаанбаатар хот

АХГ - 2022 / 162 / НА - СТА - ТМЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрх бүхий албан тушаалтны шийдвэр, удирдамж, хөтөлбөр, илтгэх хуудас зэрэг анхан шатны дэмжих баримтгүй 761,000.00 төгрөгийн томилолтын зардал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын анхан шатны дэмжих баримтгүй олгосон 761,000.00 /долоон зуун жаран нэгэн мянган/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкна дахь Аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын дарга Г.Гантулга, нягтлан бодогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Даланзул нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТӨРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ХААН КОНСАЛТИНГ АУДИТЫН
ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ

Ш.МӨНХЦЭЦЭГ

001090098



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 143/А0150058

Улаанбаатар хот

АХГ-2022/162/НХ-СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Анхан шатны баримтын иж бүрдэлгүй 16,156,300.00 төгрөгийн шатахууны зардал 10,945,000.00 төгрөгийн халдвар хамгаалалтын эд зүйлс нийт 27,101,300.00 төгрөгийн зарцуулалт байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 “Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Анхан шатны баримтын бүрдлийг ханган ажиллах, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга Г.Гантулга, нягтлан бодогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Даланзул нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ХААН КОНСАЛТИНГ АУДИТ
ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
Ш.МӨНХЦЭЦЭГ



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\0.10.10.20\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2022\0225_Auditin_2_Gazar-143.Docx

0010800461



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 141/А 0150058
АХГ-2022/162/НА -СГБ-ТМЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Жилийн эцсээрх 240,582,500.00 төгрөгийн үндсэн хөрөнгө, 36,832,200.00 төгрөгийн бараа материал нийт 277,414,700.00 төгрөгийн тооллогын баримтыг ирүүлээгүй, байгууллагын даргын тушаал шийдвэргүйгээр 13,425,500.00 төгрөгийн эргэлтийн хөрөнгийг данснаас хассан, 8,876,500.00 төгрөгийн эргэлтийн бус хөрөнгийн шинжтэй хөрөнгө нийт 299,716,700.00 төгрөгийн буруу тайлагнал байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1 "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 20 дугаар зүйлийн 20.2.6 "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 "Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.1 "Худалдах, шилжүүлэх, устгах эд хөрөнгийн талаар өмч хамгаалах Байнгын зөвлөл дүгнэлт гаргасан байх" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хөрөнгийг эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр данснаас хасах, тооллогыг хуульд заасан хугацаанд чанартай хийх, хөрөнгийг стандартын дагуу ангилан санхүүгийн тайланд тусгах биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын дарга Г.Гантулга, нягтлан бодогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Даланзул нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ХААН КОНСАЛТИНГ АУДИТ
ХХК-ИЙН АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
Ш.МӨНХЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 144/А0150058

Улаанбаатар хот

АХГ - 2022/162/НХ - СТБ - ТУС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хувь хүний орлогын албан татварын тайланд сонгуулийн гэрээт ажилтнуудын 12,429,800.00 төгрөгийн цалинг тайлагнаагүйгээс 2,819,400.00 төгрөгийн Хувь хүний орлогын албан татварын авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, хөгжлийн бэрхшээлтэй 2 ажилтнаас 566,600.00 төгрөгийн татвар суутгасан нийт 15,815,800.00 төгрөгийг буруу тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.4 "Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6 "Үндсэн ажлын газраас бусад хуулийн этгээд болон хувь хүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр ажил, үүрэг гүйцэтгэж авсан хөдөлмөрийн хөлс, шагнал, нэмэгдэл, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Оны эцэст тайлагнасан авлагын үлдэгдлийг баталгаажуулах, тайланг үнэн зөв бэлтгэх, хувь хүний орлогын албан татварын хуулийг хэрэгжүүлж ажиллах, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга Г.Гантулга, нягтлан бодогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Даланзул нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ХААН КОНСАЛТИНГ АУДИТ
ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ

Ш.МӨНХЦЭЦЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

9019120396
10.10.2022 Bichig_Kherag\Alban Shaardlag\2022\0225 Auditin 2 Gazar-144.Docx

0010800463



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

0022 оны 02 дугаар сарын 25 № 137/А0150058

Улаанбаатар хот

АХГ-0022/162/НА-07А-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 46 аж ахуйн нэгж байгууллагаас 101,571,100.00 төгрөгийн худалдан авалтын нэмэгдсэн өртгийн албан татварын төлбөрийн цахим баримт гаргуулан аваагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 "Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврын 5-д Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авалтын ажил гүйлгээний төлбөрийн цахим баримтыг бэлтгэн нийлүүлэгчээс бүрэн гаргуулан авч, хяналт тавьж ажиллах, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга Г.Гантулга, нягтлан бодогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Даланзул нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЕРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ХААН КОНСАЛТИНГ АУДИТ
ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ

Ш.МӨНХЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 142/А0150058

Улаанбаатар хот

АХГ-2022/162/НБ-СТА-ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд нийтийн болон хувийн ашиг сонирхол зохицуулах, батлагдсан төсвийн хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэлийн 7 мэдээг хугацаа хоцроон оруулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "Тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын дарга Г.Гантулга, нягтлан бодогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Даланзул нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ХААН КОНСАЛТИНГ АУДИТ
ХХК-ИЙН АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ

Ш.МӨНХЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 140/А0150058

Улаанбаатар хот

АХГ-2022/162/НБ-СТА-ТМЗ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд нийтийн болон хувийн ашиг сонирхол зохицуулах, батлагдсан төсвийн хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэлийн 7 мэдээг хугацаа хоцроон байршуулсан нь өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагын биелэлтийг ханган ажиллаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3 "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.2-т гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй нягтлан бодогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Даланзулд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын дарга Г.Гантулгад Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ХААН КОНСАЛТИНГ АУДИТ
ХХК-ИЙН АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ

Ш.МӨНХЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022

оны

02

дугаар сарын

25

№

139/А0130058

Улаанбаатар хот

АХГ-2022/162/НА-СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны төсвийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, байгууллагын тушаал шийдвэр гаргаагүй, хэмнэлт гаргаагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 43 дугаар тогтоолын 1.1 дүгээр зүйлд "Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэж заасантай нийцэхгүй байна" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Засгийн газрын 2021 оны Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллах, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга Г.Гантулга, нягтлан бодогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Даланзул нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЕРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ХААН КОНСАЛТИНГ АУДИТ
ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
Ш.МӨНХЦЭЦЭГ

ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing a summary.

